

2026.06.05 Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх, хүчингүй болгох тухай А/360

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн авсан 2 иргэнд хавсралт ёсоор газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлж байгаатай холбогдуулан сумын Засаг даргын 2025 оны А/137 дугаар захирамжийн хавсралтын 5 дугаар мөрийн Сүрэнжав овогтой Ганбаярт Дэнж баг Зүүн дэнж 1-р гудамж 2а тоот 222 м.кв газрыг гэр, орон сууцны хашааны зориулалтаар, 2021 оны А/280 дугаар захирамжийн хавсралтын 23 дугаар мөрийн Ядамсүрэн овогтой Юмчинд Уртын гол баг Баянтал 11-р гудамж 1100б тоот 750 м.кв газрыг гэр, орон сууцны хашааны зориулалтаар, гэснийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлсэн иргэдийн хуучин гэрээ гэрчилгээг хураан авч хүчингүйд тооцон шинээр газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын даамал /Г.Отгонбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.МӨНХБАЯР